



МОНГОЛ УЛС
ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2019 оны 04 сарын 19 өдөр

Дугаар А/251

Ховд

Хөрөнгө гаргах тухай

Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3 дахь заалт, 41 дүгээр зүйлийн 41.2.2 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Арабын нэгдсэн Эмират улсын Абу Даби хотноо зохион байгуулагдсан тусгай олимпын 15 дахь удаагийн зуны наадмын Бочче төрөлд хүрэл медаль хүртсэн Э.Энхтуулд аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2017 оны 02 дугаар сарын 08-ны өдрийн 25 дугаар тогтоолоор баталсан амжилт гаргасан тамирчинд урамшуулал олгох журмын дагуу 1 000 000 төгрөгийг олгосугай.

2.Уг зардалд шаардагдах 1 000 000 төгрөг /нэг сая/-ийг орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр 2019 онд хэрэгжүүлэх хөтөлбөр, төсөл арга хэмжээний 5.17-д заасан "Спортын аварга" хөтөлбөрөөс тооцож олгохыг Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга /Ч.Багдал/-д зөвшөөрсүгэй.

3.Захирамжийн хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Нийгмийн бодлогын хэлтсийн даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч /Б.Даваадорж/-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Б.ДҮГЭРЖАВ

Zax A/251 Ch
02 01260